

**“ӨНДӨРХААН” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2018 оны 4-р сарын 30

№1

Улаанбаатар хот

Компанийн 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн
тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62.1.9 зүйл, Өндөрхаан ХК-ийн 2018 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тэмдэглэл, тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг зөвшөөрч БАТАЛСУГАЙ.

ХУРЛЫН ДАРГА



Н.УЛААНХҮҮ

**“ӨНДӨРХААН” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2018 оны 4-р сарын 30

№2

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн
гишүүдийг сонгох тухай

Компанийн тухай хуулийн 62.1.7 зүйл, Өндөрхаан ХК-ийн 2018 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тэмдэглэл, тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Өндөрхаан ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүдээр:

- 1) Д.Баярсайхан
- 2) Г.Лхамсүрэн
- 3) Н.Улаанхүү
- 4) Г.Хатанболд
- 5) Г.Одонтуяа
- 6) Д.Баттулга

Өндөрхаан ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдээр:

- 7) Ө.Хангал
- 8) М.Нямсүрэн
- 9) Г.Даваа-Очир нарыг тус тус СОНГОСУГАЙ.

2. Компанийн үр ашигтай ажиллагааг хууль журмын дагуу удирдан зохион байгуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд ҮҮРЭГ БОЛГОСУГАЙ.

ХУРЛЫН ДАРГА



Н.УЛААНХҮҮ

**“ӨНДӨРХААН” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2018 оны 4-р сарын 30

№3

Улаанбаатар хот

Компанийн тухай хуулийн 62.1.13 зүйл, Өндөрхаан ХК-ийн 2018 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тэмдэглэл, тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн үндсэн үйл ажиллагаа эхлээгүй тул сонгуульт хугацаанд Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд цалин урамшуулал олгохгүй байхаар ТОГТСУГАЙ.

ХУРЛЫН ДАРГА



Н.УЛААНХҮҮ

**“ӨНДӨРХААН” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2018 оны 4-р сарын 30

№4

Улаанбаатар хот

Компани нэгтгэх үйл ажиллагааны тухай

Компанийн тухай хуулийн 62.1.2 зүйл, Өндөрхаан ХК-ийн 2017 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын Тогтоол №01, Өндөрхаан ХК-ийн 2018 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тэмдэглэл, тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Өндөрхаан ХК-ийн 2017 оны 10-р сарын 16-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаас баталсан Өндөрхаан ХК-д Тэмүүжин хүнс ХХК-ийг нэгтгэх гэрээ, журамд хоёр компанийн 2017 оны 4-р улирлын аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлангийн дүнгүүдийг оруулж эцэслэн батлах эрхийг Төлөөлөн удирдах зөвлөлд ОЛГОСУГАЙ.
2. Өндөрхаан ХК-д Тэмүүжин хүнс ХХК-ийг нэгтгэх гэрээ, журмыг эцэслэн батлах, нэгтгэх үйл ажиллагааг холбогдох хууль, журамд заасны дагуу хэрэгжүүлж, эрх бүхий байгууллагуудаар шийдвэрлүүлэх, Өөрчлөн байгуулах комиссыг байгуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлд ҮҮРЭГ БОЛГОСУГАЙ.

ХУРЛЫН ДАРГА



Н.УЛААНХҮҮ

**“ӨНДӨРХААН” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2018 оны 4-р сарын 30

№5

Улаанбаатар хот

Компанийн албан ёсны хаягийг өөрчлөх тухай

Компанийн тухай хуулийн 62.1.1 зүйл, Өндөрхаан ХК-ийн 2018 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тэмдэглэл, тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Өндөрхаан ХК-ийн албан ёсны хаяг Хэнтий, Хэрлэн, 5-р баг, Өндөрхаан, 01, утас: 99117870 байсныг өөрчилж, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Бага тойруу, 29, 58 тоот, утас 95959529 БОЛГОСУГАЙ.

ХУРЛЫН ДАРГА



П.УЛААНХҮҮ

**“ӨНДӨРХААН” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2018 оны 4-р сарын 30

№6

Улаанбаатар хот

Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай

Компанийн тухай хуулийн 62.1.1 зүйл, Өндөрхаан ХК-ийн 2018 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тэмдэглэл, тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Өндөрхаан ХК-ийн Компанийн шинэчилсэн дүрмийг Хавсралт 1-р БАТАЛСУГАЙ.

ХУРЛЫН ДАРГА



Н.УЛААНХҮҮ